



## БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ 2020 ОН




Барилга угсралт, их засварын ажил 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4.7 их наяд төгрөгт хүрч, 4.6 (97.6%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 114.3 (2.4%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.



Барилга угсралт, их засварын ажил 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноос 174.2 (3.6%) тэрбум төгрөгөөр буурахад дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн ажил 17.6 (0.4%) тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч гадаадын барилгын байгууллагын гүйцэтгэсэн ажил 191.8 (62.7%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн.


Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэгчийн төрлөөр /тэрбум төгрөг/




Дотоодын байгууллагаас төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 521.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 371.9 (3.5 дахин) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 78.3 тэрбум төгрөгт хүрч, 49.7 (2.7 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол хувийн байгууллагынх 4.0 их наяд төгрөг болж 404.0 (9.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Барилга угсралт, их засварын ажлын 28.7 хувийг орон сууцны барилга, 36.0 хувийг орон сууцны бус барилга, 32.3 хувийг инженерийн барилга, байгууламж, 3.0 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оноос инженерийн барилга байгууламжийн эзлэх хувь 10.1 пунктээр, их засварын эзлэх хувь 0.6 пунктээр тус тус өсөж, орон сууцны бус барилгынх 10.5 пунктээр, орон сууцны барилгынх 0.3 пунктээр буурсан байна.


**БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ /ХУВИАР/**



Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, төрлөөр /тэрбум төгрөг/




### Орон сууцны бус барилга, төрлөөр /тэрбум төгрөг/



Орон сууцны бус барилга нийт барилга угсралт, их засварын ажлын 36.0 хувийг эзэлж байгаа бөгөөд 2020 онд 1.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 574.4 (25.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд, үйлдвэрийн барилга 447.0 (38.7%) тэрбум төгрөгөөр, сургууль, соёлын барилга 45.6 (8.5%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилга 40.4 (34.1%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилга 29.8 (21.9%) тэрбум төгрөгөөр, орон сууцны бус бусад төрлийн барилга 11.7 (3.6%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

### Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралтын ажил /тэрбум төгрөг/



Улаанбаатар хотод 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.8 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 39.8 хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 5.0 пунктээр буурсан байна. Харин 60.2 хувийг орон нутагт баригдаж буй барилга угсралт, их засварын ажил эзэлж байна.